



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/611

Номгон

Иргэн Н.Энхтуяад тусламж үзүүлэх  
тухай


Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагч ажилтай Н.Энхтуяагийн гаргасан хүсэлтийн дагуу Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэцогт сумын иргэн Н.Цэрэнханд 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр гэрээс гараад ор сураггүй алга болсон тул түүнийг эрэн хайх ажилд 1,000,000 (Нэг сая) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2.Тусламжид зарцуулах 1,000,000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

60110495